

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН АЛБАН БУС-НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВД БАГШ, АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

2022.05.11

Улаанбаатар хот

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэ журмаар ХУД-ийн Албан бус-Насан туршийн боловсролын төвд ажилд орох ажилтныг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Энэхүү журам нь “Хөдөлмөрийн тухай хууль”, “Боловсролын тухай хууль”, байгууллагын дотоод журам болон холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудыг үндэслэл болгоно.

## ХОЁР. ЗОРИЛГО

2.1.Багш, ажилтны нөөц бүрдүүлэх, байгууллагыг чадварлаг боловсон хүчнээр ханган бэхжүүлэх, сул ажлын байранд ажиллах иргэнийг ил тод, нээлттэй сонгон шалгаруулахад оршино.

## ГУРАВ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1.Үндсэн ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох, урт хугацааны цалингүй чөлөө авах, хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаанд гарсан сул орон тоо мөн шинээр бий болсон ажлын байранд тавигдах шаардлагад нийцүүлэн ажилд авна

3.2.Багш, ажилтныг сонгон шалгаруулах ажлын хэсгийг захирлын тушаалаар томилон ажиллуулна.

3.3.Тухайн ажлын байранд тавигдах шалгуурт үндэслэн ажлын байрны зарыг цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй хүргэнэ.

## ДӨРӨВ. БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

1.Ажилд орохыг хүссэн өргөдөл

2.ТАХ-ийн анкет

3.Боловсролын гэрчилгээ, диплом, үнэмлэхний хуулбар

4.Багшлах эрхийн үнэмлэх (шинэ төгсөгчид хамаарахгүй)

5.Иргэний үнэмлэхний хуулбар

6.Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар

7.Цээж зураг-2%

## ТАВ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮЕ ШАТ

### 5.1. Анкетын шалгаруулалт

5.1.1.Анкетын шалгаруулалт хийхдээ ажил горилогчийн анкетын мэдээлэл болон ажил олгогчийн хэрэгцээ шаардлагыг хангаж буй эсэхэд үндэслэнэ.

5.1.2.Ажил горилогч нь анкетаа цахим хэлбэрээр болон биечлэн ирүүлж болох ба анкетын шалгаруулалтад тэнцсэн эсэх тухай мэдээллийг ажил олгогчоос тухай бүр мэдэгдэнэ.

### 5.2.Ярилцлага

5.2.1.Анкетын шалгаруулалтад тэнцсэн ажил горилогчийг ярилцлагад урина.

5.2.2.Ярилцлага хийхдээ хувь хүний хандлага, боловсрол, ажлын түүх, ур чадварын талаар ярилцана.

5.2.3.Ярилцлагад 2-3 хүн оролцож багийн ярилцлагыг хийнэ.

5.2.4.Ярилцлагаас гарсан үр дүнг утас болон цахимаар 1 өдрийн дотор мэдэгдэнэ.

### **5.3.Мэргэжлийн үр чадвар тогтоох шалгалт**

5.3.1.Ярилцлагад тэнцсэн ажил горилогч багшийн ажлын байран дээр өрсөлдөх бол 30 минут бэлтгэж 1 цагийн хичээл заана.

5.3.2.Бусад ажлын байран дээр шалгалт өгөх хүнээс компьютер болон тухайн мэргэжлийн шалгалт авна

5.3.3Тухайн салбарын болон хувь хүний талаар эсээ бичүүлнэ

### **ЗУРГАА. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ДҮНГ МЭДЭЭЛЭХ**

6.1.Ажлын хэсэг иргэдийг онооны дарааллаар жагсаан, захиралд танилцуулна.

6.2.Тухайн ажлын байранд тэнцсэн ажилтан байгууллагын удирдлагатай уулзаж, хөдөлмөрийн гэрээ байгуулж, ажилд томилсон тушаал гаргуулна.

6.3.Тушаалаар томилогдсон ажлын хэсэг байгууллагын ажил хүлээлцэх журмын дагуу тухайн ажилтанд бичиг баримт, эд хөрөнгө, тавилга зэргийг хүлээлгэн өгч гарын үсэг зурж, баталгаажуулна.

6.4.Мөн байгууллага дээр мөрдөгддөг дүрэм, журмуудыг танилцуулна.

### **ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ**

7.1.Сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг баримтжуулан байгууллагын архивт хадгална.

7.2.Сонгон шалгаруулалтын үед гарсан аливаа санал, гомдол, маргаантай асуудлыг тухайн өдөртөө багтаан ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, гомдол санал гаргагчид бичгээр мэдэгдэнэ.